

<https://doi.org/10.69561/mjac.v25i49.3828>

Article | Fasc.3

## Хүүхэд ширгэлэх зан үйлийн бэлгэдэл дэх аффликяцийн утгыг шинжлэх нь

Эрдэнэчулууны Гэрэлмаа 

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль, Улаанбаатар, Монгол Улс  
✉ gerelmaa0207@gmail.com

**Хураангуй:** Зан үйл (ritual) нь хүний аж амьдралтай уялдан хэвшиж тогтсон заншил, түүнтэй холбогдох аливаа хүмүүний үйл, нийгмийн загвар бөгөөд эртний олон зан үйл хүн төрөлхтний соёлын өвийг бүрдүүлж байна. Зан үйл нь соёл судлал, сэтгэл судлал, шашин судлал, угсаатны зүй, антропологи, социологи зэрэг нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны судалгааны анхаарлын төвд байсаар ирсэн.

Ялангуяа хүүхдэд холбогдох уламжлалт зан үйл нь монгол зан заншлын томоохон хэсэг бөгөөд хүүхдийг аливаа аюул, өвчин зовлонгоос хамгаалах, эрүүл энх, урт удаан наслахыг ерөөсөн гүн утга бэлгэдлийг өөртөө шингээсэн байдаг. Бид энэхүү өгүүлэлд хүүхдэд холбогдох зан үйл тэр дундаа хүүхэд ширгэлэх зан үйлийн бэлгэдлийг угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан судалж, түүний бэлгэдэл дэх аффликяцийн мөн чанарыг судлан тодруулахыг оролдлоо.

Зан үйл судлалд В.Женнеп, В.Түрнер, К.Белл зэрэг эрдэмтдийн дэвшүүлсэн аффликяци хэмээх ойлголт буюу хүний оршихуй дахь аливаа айдас, зовлон зүдгүүр, зөрчил, тэмцлийн үед хийж буй үйлдлийн мөн чанарыг шинжлэх нь нийгэм, соёлын өөрчлөлт, ард түмний оюун санаа, зан үйлийн онцлогийг гүн гүнзгий ойлгоход дөхөм болно гэж үзэж байна.

**Түлхүүр үгс:** зан үйл судлал, аффликяци, уламжлал, бэлгэдэл, ширгийн хэрэглэгдэхүүн, лиминал, зан үйлийн мөн чанар

## Analyzing the affliction Meaning in the Symbol of the Ritual of children's purify

Gerelmaa Erdenechuluun 

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia  
✉ gerelmaa0207@gmail.com

**Abstract:** A ritual is a social model intertwined with human life, practices, and customs, creating a framework for human actions that have shaped cultural heritage through ancient rituals. These rituals have been a central focus of research across various



social sciences and humanities, including cultural studies, psychology, religious studies, ethnology, anthropology, and sociology.

Traditional rituals specifically related to children form a significant part of Mongolian customs, passed down through centuries. They embody profound symbolic meanings, such as safeguarding children from potential dangers, illnesses, and hardships while bestowing blessings for health and longevity. This article explores the symbolic aspects of rituals associated with children, with a focus on the ritual of purifying, using ethnographic field research to examine the nature of affliction embedded in these symbolic actions.

In ritual studies, concepts like “affliction”, introduced by researcher such as V.Genep, V.Turner, and C.Bell, involve analyzing actions undertaken in response to fear, suffering, conflict, or struggle. This concept helps deepen our understanding of social and cultural transformations, people’s mentality, and the main characteristics of rituals in a given community.

**Keywords:** *ritology/ritual study, affliction, tradition, symbol, ritual offerings, liminal, the main characteristic of ritual*

## Оршил

Зан үйл (ritual)-ийг шашин судлалын судлагдахуун болох талаас нь болон зан үйл судлал /ritology or ritual study/ хэмээн салбар дундын судалгаа болох талаас нь судлан тодорхойлж, “зан үйл судлалын онол, арга зүй”-г дэвшүүлэн судалсаар байна. Тухайлбал, 1970-аад оноос эхлэн Р.Л.Гримс, Р.Раппапорт, Э.Дюркгейм, Э.Лич, В.Тернер, А.Женнеп, К.Белл тэргүүтэй эрдэмтэн судлаачид өөрсдийн онол, арга зүйг боловсруулан зан үйл судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрийг оруулсан юм.

Юуны түрүүнд зан үйл судлаачдын үзлээр зан үйл бол “үйлдэл (action)” бөгөөд өргөн утгаараа нийгмийн бүтэц ба хүний ухамсар, оюун санаа, соёлыг бүрдүүлдэг (Cossu 2010) гэж үздэг. Сүүлийн жилүүдэд нийгэм, хүмүүнлэгийн салбар тэр дундаа соёл судлал, нийгэм-соёлын антропологи, түүх, сэтгэл судлал, социологийн ухаанд хүний ахуй, оршихуйг ойлгох, тайлбарлах үүднээс зан үйл, түүний бүтэц, үүргийг онцгойлон судалж байна. Иймд аливаа үндэстэн, угсаатны ахуй, соёл, түүний онцлогийг тодруулахад тухайн ард түмэнд уламжлагдан ирсэн зан үйлийг нарийвчлан судлах шаардлагатай юм.

Өрнө дахины олон оронд хүний оршихуйг төрсөн цагаас нь эхлэн тооцдог бол монголчууд хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдсэн цагаас хүний оршихуй эхэлнэ хэмээн үзэж, жирэмсэн үед баримтлах дэг, хорио цээрээс эхлэн амьдралын мөчлөг, шилжилт бүрд тодорхой зан үйл гүйцэтгэсээр ирсэн. Ялангуяа амьдралын эхлэл нь хүндтэй чухал үйл явдал тул түүнд холбогдох зан үйл нь нийгэм соёлын орчин ахуйд уламжлагдан хөгжиж ирсэн байна. Өөрөөр хэлбэл, хүүхэд тээх, төрүүлэх, өсгөн бойжуулах нь биологийн үйл явц төдийгүй нийгэм, соёлын хувьд аль ч нийгмийн онцлог, соёлын үнэт зүйлсийг төлөөлсөн бэлгэдэлт зан үйлээр бүтээгддэг. Монголчуудын дунд хүүхдийг угтан авах ёс, зан үйлээс гадна хүүхдээр хүн хийх эрдэм ухааны уламжлал бүрэлдэн тогтож, үеэс үед уламжлагджээ. Ялангуяа

хүүхдийг нялх, балчир насанд нь буюу эхийн хэвлийгээс мэндэлсэн цагаас эхлэн сэвлэг үргээх хүртэлх эл хугацаанд онцгой анхаарал хандуулж, хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тогтоох өвөрмөц зан үйлийг гүйцэтгэдэг. Иймд монголчуудын хүүхдэд хийж буй зан үйл, түүний мөн чанарыг тодорхойлох судалгаа нь тухайн ард түмний ертөнцийг үзэх үзэл, хүний оршихуйн үзэл төсөөллийг тодорхойлох нийгэм-соёлын чухал ач холбогдолтой юм.

Хүүхдийг элдэв аюул ослоос амь нас, эрүүл мэндийг хамгаалах, энх өсгөн бойжуулах, тогтдоггүй хүүхдийг тогтоох зэрэгт уламжлан ирсэн зан үйлийн дундаас хүүхэд ширгэлэх зан үйл нь аргадах домнохуйн хэлбэрээр өдгөөг хүртэл олон нийтэд түгээмэл хэрэглэгдсээр байна. Монголчууд хүүхдийг энэ ертөнцийн сайн мууг ялгахгүй, өөрийгөө хамгаалж үл чадах шинэ бүхний эхлэл, шинэ амьдрал хэмээн ихэд нандигнах бөгөөд хүмүүний ертөнцийн бус, хорон муу зүйл үр хүүхдийг хоргоон зовоож байна хэмээн үзэж өдөр тутамдаа “ширгэ” хэмээх зан үйлийг гүйцэтгэж, арга ширгэ үйлдэж иржээ.

Хүүхэд ширгэлэх зан үйлийн талаар ХХ зууны угсаатны зүйчдийн (С.Бадамхатан, Н.Уртнасан, Д.Тангад, Г.Батнасан, Г.Цэрэнханд, Ц.Аюуш, Б.Лхагвасүрэн) цуглуулсан эх хэрэглэгдэхүүнийг эс тооцвол хүүхдэд холбогдох зан үйл, түүн дэх бэлгэдэл, мөн чанарыг тодорхойлох судалгаа монголд төдийлөн нарийн хийгдээгүй байна. Харин Д.Тангадын “Монгол домын тайлбар толь” хэмээх бүтээлд хүүхэд ширгэлэх домын хэд хэдэн хувилбарыг тэмдэглэж, зарим домын утгад өөрийн үнэлэлт дүгнэлтийг өгчээ.

Мөн монголчуудын “хүүхэд ширгэлэх, муу зүйлсийг хөөн зайлуулах, сүнс дуудах, хүүхдийн заяачтай холбогдсон өвөрмөц зан үйл”-ийн талаар гадаадын нэрт эрдэмтэд Л.Н.Жуковская, В.Хайссиг, Ч.Баудинг, С.Шинкевич нар сонирхон судалсан байдаг. Тухайлбал, С.Шинкевич хүүхэдтэй холбогдох дом, зан үйлийг судлан, “Хүүхдийг байгаль ертөнцийн ивээлд даатгах, гэр орон, эцэг, эхтэй нь холбоог нь бататгах”-д хийдэг зан үйл зэргээр ангилан төрөлжүүлж, зан үйлийн учир холбогдлыг тайлан тайлбарласан нь бидний судалгаанд ач холбогдолтой юм.

### Судалгааны арга зүй

Зан үйл судлалын үүднээс, тухайлбал, антропологич А.Женнеп “...Зан үйл бол нийгмийн нэг байдлаас нөгөөд шилжих хувь хүний амьдралын мөчлөгтэй холбоотой үйл ажиллагаа бөгөөд бүхий л нийгэмд хүн төрөхөөс үхэх хүртэлх амьдралын нэг үе шатаас нөгөөд шилжих шилжилтийг заагласан хэд хэдэн үе шатыг дамждаг. Лиминал үе шилжилтийн өмнөх, шилжилтийн, шилжилтийн дараах үе буюу тусгаарлах, шилжих, нэгдэх үе бүтэцтэй. Шилжилт нь ихэвчлэн зан үйлийн шинж чанартай үйл ажиллагаагаар илэрдэг...” (Genner 1961) гэж үзсэн. Түүний эл онол, арга зүйг үндэслэн Виктор Түрнер өөрийн онол арга зүйг боловсруулсан бөгөөд түүнийхээр “...зан үйл нь шилжилтийн үед оролцогчид нийгмийн хэм хэмжээнээс түр хугацаанд гарч, шилжилтийн үйл явцад ордог болохыг тодруулсан. Энэ шилжилт нь нийгмийн шинэчлэлд чухал үүрэгтэй” (Turner 1967). Лиминал үе бол аль нэг бүтэц тогтолцоо, ангилал тодорхойлолтод багтдаггүй, хууль ёс, хэв журамд хамаардаггүй, завсрын нөхцөл бөгөөд нийгэм дагаж мөрдөж байгаа цаг хугацаанаас гадуурх нэг ёсны чөлөөт бүс болдог. Энэ үеийг “Коммунитас” гэж нэрлэсэн байдаг (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2012) гэж үзсэн.

Виктор Түрнер Замби улсын Ндембу нарын дунд хийсэн судалгаагаараа хүмүүний аливаа айдас, зовлон зүдгүүр, амьдралын тэнцвэрт байдал алдагдсан зөрчил, тэмцлийн үед хийж ирсэн зан үйлийг судалсан бөгөөд эдгээр зан үйлийг хүмүүс нийгэм болон амин чанарт үүргээ биелүүлээгүйгээс үүдэлтэй өвөг дээдэс, ад зэтгэрийн нөлөөгөөр бий болсон хохирол, зовлонг засах оролдлого гэж үзжээ. Ийм төрлийн зан үйл нь амьдралын тэнцвэрийг сэргээж, айдас, зовлонг намдаах зорилготой бөгөөд сүнслэг хүчнүүдтэй харилцах бэлгэдлийн үйлдлүүдийг агуулдаг байна (Turner 1991) хэмээгээд эл зан үйлийг зовлон зүдгүүрийн зан үйл буюу аффликяци (affliction) хэмээжээ. Өөрөөр хэлбэл, тэрээр хүний айдас, зовлон зүдгүүр, сэтгэл санааны зовнилт байдлаа арилгах, бусдад даатгахдаа үйлдэж буй зан үйл, түүн дэх бэлгэдлийн агуулгыг томъёолохдоо аффликяци хэмээх ойлголтыг гаргаж ирсэн байдаг.

Хүүхэд ширгэлэх зан үйлийн бэлгэдлийг аффликяци ойлголтын үүднээс тодруулахдаа 2020-2024 оны хооронд 16 аймаг 123 суманд хэрэгжүүлсэн хээрийн судалгааны материалыг эш үндэс болгов. Үүнд: “Миний монгол: Өв соёлын эрэл хайгуулчид” ТТБ-аас 2020 онд Дундговь, Өмнөговь, Төв аймагт, 2021 онд Архангай, Хөвсгөл, Завхан аймагт явуулсан хээрийн судалгаа (Миний монгол төсөл 2020), Цахим Суварга ТББ-аас 2022 онд Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймагт (Соёлын яам 2022), 2023 онд Булган, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Хэнтий, Дорнод аймагт (Цахим Суварга ТББ 2022-2023) , 2024 онд Увс, Булган аймагт хэрэгжүүлсэн угсаатны зүйн хээрийн судалгаа (Баядын өв соёл ТББ 2024), 2022, 2023 онд явуулсан Соёлын биет бус өвийн улсын үзлэг, судалгаа (Соёл урлагийн газар 2023)-ны хүрээнд цуглуулсан эх хэрэглэгдэхүүн, медиа баримтжуулалтын материалыг ашиглалаа.

Судлаач, эрдэмтэд хүүхэд ширгэлэх зан үйлийг хэрхэн үйлддэг тухай голчлон тодруулж, түүний утга, бэлгэдлийг дашрамд дурдаж ирсэн боловч тухайн зан үйлийн үүрэг, үйлдэх шаардлага, шалтгаан хийгээд түүний мөн чанарт онолын үнэлэлт, дүгнэлт өгөх зүй ёсны шаардлага үгүйлэгдсэн хэвээр байна. Тиймээс бид энэхүү судалгаагаар хүүхдийн айдас ачирхлыг үргээх, өвчин эмгэгийг арилгах зорилгоор хийж ирсэн ширгэ хэмээх зан үйл, түүний зарим бэлгэдлийг аффликяцийн ойлголтын үүднээс судлан тодруулахыг оролдлоо.

Хүүхэд ширгэлэх зан үйлийн бэлгэдэл дэх аффликяцийн утгыг тодруулахыг оролдсон энэхүү өгүүлэлд ажиглалт, харьцуулалт, угсаатны зүйн хээрийн судалгааны аргыг гол болгон хэрэглэсэн болно.

### **Судалгааны үр дүн**

Монголчууд хүүхэд уйлах, өвчин ороох, яр шарх гарах, зүүдэндээ яраглах, нойр хоолонд муудах, хөхөө хөхөхгүй болох, зөн совингийн шинжтэй ихээр инээх зэрэг хүүхэд тавгүйрсэн, хэвийн бус байдлыг харгалзан ширгэ хийнэ. Ширгийг гол төлөв бүрэнхий, үдэш оройн цагаар гал, ус, давс, төмөр, тугалга, лаа, сүү /нийтлэг бус/ зэргийг ашиглан хийх бөгөөд хүүхдэд илрэх шинж тэмдгийг ажиглан өөр өөр аргыг сонгоно. Ямар төрлийн ширгэ хийхээс хамааран эд зүйлсээ бэлтгэн, хүүхдийг эх нь голдуу ширгэлэх бөгөөд зарим нутагт тусгайлан лам, домч хүмүүсийг урьж залж ширгэлүүлнэ.

Хүүхэд ширгэлэх зан үйл нь хэрэглэгдэхүүн талаасаа дараах хэлбэртэй байна.

1. Галд чулуун давс хийн хүүхдийг тэврэн галын дээгүүр нар зөв эргүүлж ширгэлэх
2. Ширгийн чулуун дээр (ширгэ хийхэд зориулсан хавтгай чулуу байх агаад гэрийн баруун хатавчны орчимд байна) арц, давс хийн, хүүхдийн толгой, бүсэлхий 4 мөчийг утаж ширгэлэх.
3. Ширгэ хийхэд зориулж тусгайлан зэхсэн сэтэрхий аяга юм уу ширгийн шанага (ширгийн чулуутай адил тусгайлан ширгэ үйлдэхэд зориулсан тусгай жижиг шанага байх бөгөөд мөн адил гэрийн гадна баруун хаяанд байлгана) сэлтийг бэлтгэн, түүндээ ус хийж гэрийн босго, хаяа, тулганы дөрвөн тотго зэргээс чимх шороо юм уу тогооны хөө хийж хүүхдийн нүд рүү харуулж нар буруу эргүүлж ширгэлэх.
4. Ус эргүүлэхтэй адил бэлтгээд, галаас цог авч усан дээрээ хийж ширгэлэх. Дээр нь давс, арц хийх нь бий.
5. Хайлуулсан тугалга, лаа зэргийг ус руу хийн шогшоолгон дуу гаргаж ширгэлэх. Ус руу хийн царцаасан тугалга болон лааны дүрсийг гэрлийн дэргэд барьж, сүүдрийг нь харж юунаас айсан болохыг нь таамаглан, дэрэн дор нь хийж хонуулдаг ба зарим газарт дээл, хувцсанд нь зүүж өгдөг.
6. Төмөр улайсган хүйтэн усанд дүрж, шархийн дуу гаргаж ширгэлэх. Мөн улайсгасан төмрийг хүүхдэд харуулан, нүднээс нь холдуулж ойртуулах байдлаар зангаж гэнэдүүлэн, нүүр лүү ус сүрчин цочоож ширгэлдэг.
7. Нэн ховор боловч Хэнтий, Дорнод аймгийн зарим буриад, хамнигадын дунд сүүгээр ширгэлэх тохиолдол бий.

Ширгэлэх зан үйлд хэрэглэгдэж буй хэрэглэгдэхүүнээр нь төрөлжүүлэн үзвэл, гал, ус, чулуу, давс, төмөр, сүү, лаа зэрэг нь ширгийн үндсэн хэрэглэгдэхүүн болох нь ажиглагдаж байна. Түүнээс гадна эдгээр ширгийн хэлбэрүүдэд гал, ус, давс, төмөр нь ширгэ бүрд давтамжтай хэрэглэгддэг. Иймд ширгийн зан үйлийн эдгээр хэрэглэгдэхүүн, түүний бэлгэдлийн талаар ерөнхийлөн авч үзье.

*Гал ширгэ:* Монголчуудын дунд эртнээс галаар дамжуулан ариутгал хийдэг байсан тухай түүхийн сурвалж зэрэгт тэмдэглэсээр ирсэн. Тухайлбал, Плано Карпини "...эзэн хаанд бараалхах харь газрын хэнийг ч гэсэн ийнхүү хоёр галын дундуур оруулж ариутгадаг ёстой. Түүгээр ч барахгүй хүн шөнө орой гадагш яваад эргэж ирэх үед гэрийн хүн гал барьж гадначлан ирсэн хүний биеийг галаар гурван удаа эргүүлж сая гэртээ оруулдаг" (Карпини 2022) хэмээн тэмдэглэжээ. Өдгөөг хүртэл нярай хүүхэдтэй айлын эзэн хол газар олон хоногоор явж гэртээ ирэх юм уу оршуулга /үхээрийн газар/, ажил явдал зэрэгт оролцсон бол гэртээ орохдоо гэрийн хаалганы хоёр талд гал гаргах юм уу шүдэнз зурж ариутган гэртээ ордог, шөнийн цагаар зочин гийчин ирэх болбол, хүүхэд хөлсөн уйлагнана гэж хатавчны хоёр тал руу галтай цучил цог хаях, зээг татах дом хийдэг. Энэ нь нэг талаас хөл хорих тэмдэг болохоос гадна хаалганы хоёр талд улаан бөс уяж тэмдэглэсэн нь хоёр галын дундуур гаргаж галаар ариутгаж буйтай агаар нэг дүрст бэлгэдэл юм. Дархад угсаатны дунд хүүхдийн өлгийн цамхараан дээр /нээлхий дээр/ буюу хүүхдийн зулай орчимд болон баривч дээлийн малтаасанд улаан бөсөөр (+) тэмдэг хаддаг. Хүүхдийн модон өлгийн цамхараа нь тоононы бэлгэдэлтэй. Тэр дундаа ачирхан

хүүхдийн өлгийн цамхарааг зориуд улаан харганаар үйлдэх нь ч буй. Тоононы дүрс галын бэлгэдэл болох тухай С.Дулам “Монгол бэлгэдэл зүй” бүтээлдээ “... дугуй тооно дүрс нь угтаа хас болохыг зориуд заасан байна. Монгол соёлын уламжлалт хас тэмдгийн бүтцийн хамгийн гол зүйл буюу үндсэн бүтэц нь үнэн хэрэгтээ туухай тамга байгаа бөгөөд туухай тамга бол анх гал гаргасан хоёр чагтан хавируул буюу галын үүслийг бэлгэдэгч тэмдэг...” (Дулам 2011, 61) хэмээжээ.

Түүнчлэн өлгий, уяа, дээл хувцас зэрэг хүүхэдтэй холбогдох эд хэрэглэлийг галаар ариутгадаг уламжлал монголчуудын дунд түгээмэл бий. Галын бурхан эрхшээх буюу хүүхдийн бүхий л эдлэл хэрэглэлийг галд ариулж буй нь галын бурхны ээл ивээлд багтааж буй зан үйл бөгөөд галын дөл, цог, үнс, нурам, хайч, тулга, галын дөрвөлж зэрэг эдлэл хэрэглэлийг ариун чанартай, ариусуулах шидтэй гэх үзлээс үүсэлтэй арга засал (Тангад 2020, 72) гэж үздэг.

Мөн хүүхдийг бор халзан туулай болгохдоо зарим нутагт хүүхдийн галын заадас (хүүхдийн зулай)-аас хамрын үзүүр хүртэл хөөгөөр татаж домнодог нь ч бий. Хүүхдийн зулай нийлэх хүртэлх заадлыг “галын заадас” гэж нэрлэдэг. Баяд угсаатны дунд хүүхдийг ширгэлэхдээ хар өнгийн даавуугаар толгой, нүүрийг нь халхалж хучаад ширгэлдэг. Зарим нутагт малгай буруу харуулж өмсгөх, өлгийн даавуугаар нүүрийг нь халхлах нь бий. Хүүхдийг бор халзан туулай болгож буй эл зан үйл болон хар даавуугаар хучиж ширгэлж буйн чанадад хүүхдийн гуравдагч мэлмий буюу хүний нүдэнд үл үзэгдэх зүйлийг харснаас үүдэлтэй, түүнээсээ айсан учир ачирхаж уйллаа хэмээгээд галын заадас, зулай, гуравдагч мэлмий хэмээгчийг хааж халхалж, хүний нүдэнд үл үзэгдэх элдвийн зүйлийг харахгүй гэсэн санаагаар галаар ариулж буй бололтой.

*Төмөр ширгэ:* Галаар ариулах зан үйлийн дотроос “галын ширээс” хийх зан үйл бидний сонирхлыг ихэд татаж байна. Уг зан үйл нь дарханы хөөрөг тахиж зан үйл бөгөөд зарим тохиолдолд энэхүү зан үйлийг хүүхэд ширгэлэхтэй адил утгаар ойлгож шинийн 9-тэй өдрүүдэд хүмүүс зорьж очин хүүхдээ ариулдаг. Монгол Улсын Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч П.Эрдэнээ нь 9 дэх үеийн дархны хөөргийг өвлөн тахиж байна. Эрдэнээ гуайн гүйцэтгэж буй эл зан үйлд тувачууд хүүхэд багачууд тогтохгүй, өвдөж ачирхсан үед хэдийд ч гэсэн сайн өдрийг сонгон дарханыд ирж энэ зан үйлийг хийлгэдэг (Баатархүү 2017, 308). Бэлтгэсэн төмрийг хөөрөгдөн улайсгаж дөшин дээр алхаар цохиход чанга дуу гарч гэр дүүрэн улаан оч үсэрдэг. Эл зан үйлийг харсан хүний өвчин эдгэрч, ачирхан хүүхэд ачирхахаа больж, тогтдоггүй хүүхэд тогтдог гэдэг. Энэ нь төмөр улайсган хүүхдийн нүд рүү ойртуулж, холдуулж хараанд тогтоодог ширгийн зан үйлтэй үзэгдлийн хувьд төстэй байна. Үүнээс гадна халуун төмрийг хүйтэн ус руу дүрж шархийх дуу гарган ширгэлнэ. Нэг талаас хүүхдийг цочоож, нөгөө талаас нүд рүү нь гал тусган нүдэнд харагдсан элдэв муу зүйлийг галын эрчмээр ариуллаа гэсэн санаа юм. Хүүхдийг ширгэлэхдээ, ган ширгэ суухаа, гангаа ширгэ суухаа хэмээн шившин ширгэлэх хоршоо хэллэг төмөрт ширгэтэй холбоотой хэлэгдэх болсон шившлэг бололтой.

*Усан ширгэ:* Ширгэ хийх сэтэрхий аягатай усанд гэрийн босго, зуух, ор, хаяа тойруулан чимх шороо хийгээд дээр нь цог давс зэргийг нэмж дуугарган хүүхдийн дэргэд ирж,



Мэлмийн хар нь рашаандаа

Мэддэг сэв нь усандаа

Хар буруу нь рашаандаа

Хамаг бузар нь сэвэндээ ширгэ ширгэ ширгэ хэмээн шившин ширгэлээд, муу зүг рүү цацан эргэж харалгүй гэртээ ордог. Уг ширгийн зан үйлээс харвал, хүүхдийг ачирхуулагч аливаа муу зүйлийг усанд шингээж буй нь тодорхой. Усаар хийх ширгийг ус эргүүлэх, усан ширгэ гэхчлэн нэрлэхээс гадна ийм төрлийн ширгийг зарим нутагт хүүхэд ямарваа зүйлийн муу зөн совин, зүүд, эсвэл ямар нэгэн далд муу зүйл харснаас болж уйлахад голдуу ширгэлдэг байна. Түүнчлэн, халуун чанартай гал дээр хүйтэн чанартай ус хийн шогшоолгож буй тус зан үйл нь сайн ба муу, хоргоогч ба хамгаалагч, эсрэг тэсрэгийн бэлгэдэл болохын хувьд бэлгэдэж, сүүлд нь аливаа мууг эвцэлдэн дарж байгаагаар илэрхийлэгддэг гурамсан шинжтэй. Усан дээр аянга бууддаггүй хэмээн тэнгэрийн их дуу цахилгаантай үед аяганд ус хийн тооно голлуулан тавьдаг дом бий. Ширгийн гол агуулга нь байгалиас нийлэх боломжгүй хоёр өөр шинж чанар бүхий эсрэг тэсрэгийг нийлүүлж үйлдэх зан үйл ажээ.

Галыг ариулах шидтэй, өөдөө эрчимтэй гэж үзвэл ус нь үүний эсрэг утга бүхий уруу урсгалтай, шингээгч эрчимтэй. Ширгийн зан үйл дэх усаар дамжуулж аливаа зүйлийг дуудан ирүүлж аягатай усанд тогтоож байгаатай адил зан үйлүүд бөөгийн сүнс дуудах зан үйл (Золбаяр, Ганболд 2014, 201), дархад бөөгийн угаалга буюу хорхог эмчилгээний (Пүрэв 2014, 326-327) зан үйл, аягатай усаар аливаа эерэг, сөрөг бүхий л зүйлийг шингээн дуудаж ирүүлдэг, зайлуулдаг тухай зан үйлүүд монголын ахуй соёлд тэр дундаа бөөгийн зан үйлд тодорхой харагдана. Сэтэрхий аяга, шанага ашиглаж буйн учир нь сөрөг эрчмийг дуудан ирүүлж буйтай холбоотой. Усаар ширгэлж буй зан үйлд босгоны шороо, зуухны дөрвөн булан болон тогооны хөө зэргийг ус руу хийдгийг дээр дурдсан билээ. Монголчууд босгоны орчимд галын бурхан оршино гэж үздэг, гэрийн босго нь гэр доторх сахиус болон буян заяаг хамгаалж, гадаа байгаа муу муухайг гэрт оруулахаас сэргийлдэг (Жуковская 2010, 21) гэжээ. Ус руу гал болон халуун чанартай зүйлийг хийлгүйгээр ус эргүүлж буй тус ширгэ нь босгоны шороо, тогооны хөө зэргээрээ далд утгаар галыг төлөөлүүлсэн байж болохоор байна.

*Давсан ширгэ:* Ширгэ хийх зан үйлийн гол хэрэглэгдэхүүн давс болох тухай бид дээр дурдсан билээ. Ширгийн давс хэмээн зарим нутагт тусгайлан аравнайж, шившин хадгалах нь ч бий. Давсыг монголчууд өдөр тутамдаа өргөн ашиглаж байсны хувьд давстай холбогдсон зарим өвөрмөц дом, зан үйлүүд байна. Юун түрүүнд дэлхийг үүсгэсэн гол нөхцөлт шалтгаануудын нэг нь солир хэмээн тайлбарладаг. Эрдэмтэд 30 жилийн өмнө 4,5 тэрбум жилийн настай солир олсон бөгөөд судлах явцдаа бүрдүүлэгч нэгдэлд хоолны давс байгааг тогтоосон байна. Эл судалгааны гол ололт нь давсны талст ширхэгт усны дуслууд хадгалагдаж байсныг илрүүлсэн бөгөөд давс бүхий солир нь дэлхий усан гариг болохын голлох нэгдэл гэдгийг нотолсон явдал юм (Zega 2023, 1063). Бидний үзэхээр гал руу ус хийн, шогшоолгон дуугаргаж ширгээдгийн адил давсыг гал руу хийж ширгэлж байгаа нь давсны мөн чанарыг устай зүйрлэж буй хэрэг. Монголчуудын уламжлалд давс нь хатуурсан хатаасан нулимсыг төлөөлдөг (Дулам 2018, 387) гэж үздэг. Ямар нэг зүйл

эрэн хайхдаа гартаа давс атгаж хайдаг бол ус эргүүлж домнохдоо аягатай усанд хүүхдийг айлган буй муу муухай зүйлийг дуудан оруулдагтай адил, айлаас давс гуйдаггүй гэх нь хар ус гуйдаггүйгэй адил, давс асгавал заавал ус асгаж уусгадаг, хогийн шүүр зэрэг бузар муухай зүйл хүргэхийг цээрлэдэг байх жишээтэй. Ийнхүү ус-давсыг адилтган хэрэглэж ирснээр хүүхэд ширгэлэх зан үйлд хэрэглэж буй ус болон давс бол нэг бүхэл хийгээд нэг зүйлийн хоёр өөр хэлбэр гэж үзэж болох юм.

Дэлхий дахинаа зарим үндэстэн, угсаатны дунд хүүхдийг хамгаалах, ариулах зорилгоор харилцан адилгүй зан үйл гүйцэтгэж иржээ. Бидний үзэхээр онго зүүсгэл бус тодорхой бэлгэдэлт зан үйлээр буюу хүүхдийг гаднын аливаа хорон муу зүйлээс хамгаалах зорилгоор *rite of magic protection/apotropaic magic* буюу хүүхдийг хамгаалах домын зан үйл болон апотропын шид хэмээн эртний Египет, Индонез, Англи, Кени, Ирланд, Шотланд, Хавайн уугуул ард түмний дунд тус зан үйлийг гүйцэтгэдэг байсан ажээ. Тухайлбал, эртний египетчүүдийн аливаа хорон муу ёрын сүнснийг зайлуулах, хамгаалах зорилгоор Хека, Хорус, Таверет бурхны дүрс бүхий саванд ус хийн, усыг муу ёрын сүнснийг зайлуулах зорилгоор хүүхэд болон өвчин ороосон хүмүүс рүү цацах, уулгах байдлаар тусгай зан үйлийн дагуу үйлдэж эдгээдэг байв (Robert 2008, 16). Түүнчлэн англи, ирландын овог аймгууд хүн төдийгүй өөрсдийн тэжээвэр мал амьтныг хүртэл өвчин тусах, зүүд зөн тавгүйрхэх, дахин дахин өвчлөл гарах үед хоёр хэсэг газарт гал асааж хүн, малыг галын хооронд гаргаж ариутгадаг (Hutton 1996, 221). Эртний афинчуудын дунд хүүхдийг онго зүүсгэлээс гадна өмссөн хувцас руу нь нулимаж, давс цацах, хувцсыг нь сольж өмсгөх буюу эрэгтэй хүүхдэд эмэгтэй хувцас, эмэгтэй хүүхдэд эрэгтэй хувцас, боолын хувцас зэргийг өмсгөж домнох зан үйлүүд байв (Lesley 2015). Дээрх улсын ард түмний дунд буй хүүхдийг хамгаалах эдгээр зан үйл нь өөрийн ахуйд зохицуулан барилга байгууламж, ваар сав, бурхан, шүтээний дүр дүрслэл бүхий эдлэлээр дамжуулан тус зан үйлийг үйлддэг бол монгол зан үйлийн уламжлалд гал-төмөр хийгээд ус-давс зэрэг өөр өөр төлөөлөл бүхий хэрэглэгдэхүүнийг нэгэн бүхэл шинжээр нь бэлгэдэж, ширгийг үйлдэж ирснээрээ онцлог байна.

Хүн өөрийн үр хүүхдэд тохиолдож буй ер бусын зүйлсийг буюу өөрийн таван мэдрэхүйгээр батлах боломжгүй далд утга шалтгааныг танин мэдэж, мэдлэгийг бүтээж ирсэн. Гэвч энэ нь зөвхөн практик мэдлэг төдий бус. Кассирерын үзсэнээр “амьтдаас хүний ялгагдах чухал шинж гэвэл хүн физик ертөнцөд амьдардаг төдийгүй символик универсумд амьдардаг. Хэл, домог, шашин, шинжлэх ухаан зэрэг универсумын хэсгүүд символик сүлжээ байгуулах янз бүрийн суваг, хүний туршлагын нарийн нийлмэл эс эд мөн. Символ бол мэдрэхүйн олон янз байдлын формаль синтез мөн” (Гомбосүрэн 2019) гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, хүн танин мэдэж буй зүйлийнхээ язгуур утга санааг хэлбэр бүтцээр харуулж буй танин мэдэхүйн хэлбэр нь бэлгэдэл юм. Хүүхэд ширгэлэх зан үйлээс үзвэл, хүмүүний ертөнцөд аливаа таван мэдрэхүйгээр мэдрэгдэхгүй ч аливаа хорон муу зүйл байдаг гэдгийг мэдэрч харуулсан тусгал нь ус, давс зэргээр илэрхийлэгдэж байна. Иймд зан үйл болон түүний систем бол хүмүүсийн танин мэдэхүйн явц бөгөөд хүн, ертөнц хоёрын харилцааг зохицуулж байдаг хэрэглүүр гэж үзэх үндэстэй.

Хүүхдийг ширгэлэх зан үйлийг хүчжүүлэх гол илэрхийлэл нь ширгийн шившлэг үгс болно. Үүнд:



Хар нохойноос болов уу, шар нохойноос болов уу  
Хөөтэй тогооноос болов уу, хөлстэй тохомноос болов уу ширгэ ширгэ ширгэ  
...Хуцдаг нохойноос болов уу  
Хурмаст тэнгэрийн амьтнаас болов уу  
Холын айлчингаас болов уу  
Хэзээ байтлаа голомтон дээгүүрээ сандайж байв ширгэ ширгэ ширгэ...  
...Айлаас болов уу, алаг нохойноос болов уу  
Холоос болов уу, ойроос болов уу  
Надаас болов уу, нагацаасаа болов уу ширгэ ширгэ ширгэ...  
...Хүүхэн хүнээс болов уу, Хотны хүнээс болов уу  
Айлчин гийчнээс болов уу, Аальгүй эмээс болов уу  
Бух мөргөх гээ юу? Буур хазах гээ юу? эхэн дом эхэн дом эхэн дом, ширгэ ширгэ ширгэ... гэх мэт.

Ширгийн эдгээр шившлэг үг нь нутаг нутагт харилцан адилгүй боловч гол агуулга, шүлэглэлийн хэлбэр төсөөтэй байна. Хүүхдийн айсан ямарваа зүйлийн шалтгаан болох хар нохой, шар нохой, алаг нохой, хөөтэй тогоо, хөлстэй тохом, холын айлчин, нагац, хурмаст тэнгэрийн амьтан гэхчлэн оноосон тухайн зүйлийг өнгө, хэлбэр хийгээд ялгац зүйлээр нь оноож хэлдэг. Хүүхдийг хөлстэй морьтой ирсэн нагацын талын хүнээс амархан айж хөлсдөг хэмээн үзэх учир хөлснөөс үүдэлтэй гэх утгаар “хүүхэд хөлслөө” хэмээнэ. Шившлэг үгнээс харахад, нохой, тогоо, айлын хүн гэхчлэн давтагдаж байгаа эдгээр үгс хүүхдэд морины төвөргөөн, нохойн хуцалт, хөлсний үнэр, хөл хөдөлгөөн зэргээр танил болоогүй, гайхах өрнөлт үйл явдал, дуулиан шуугианаас үүдэлтэйгээр айж эмээсэн, тухгүй байдал үүссэн учир шалтгааныг дуудан тайлж буйгаар ойлгож болохоор юм. Энэ тухай судлаач Д.Тангад “Дом шившлэгийн эдгээр шившлэг үг нь тухайн хийж буй зан үйлийг үгийн хүчээр илүү хүч оруулах санаа бөгөөд зарим тохиолдолд нажтай үгийн хүчээр муу муухайг дийлэх санаа болно” (Тангад 2020, 106) гэжээ. Мөн академич Д.Цэрэнсодном “Дом шившлэгийн үг нь хүн төрөлхтний үгийн “ид шид”-д итгэн биширч байсан эрт балар цагт үүсэж буй болсон” хэмээгээд “орчин үеийн “дом шившлэг” хэмээх хоршоо үгийн маягтай хэрэглэх болсон эл хэллэг нь угтаа үүрэг хэрэглээний хувьд зааг ялгаатай өөр өөр ойлголт байсан гэж үзмээр байна. Эм домнолго хийж хэлдэг үг нь шившлэгийн чанартай учраас “дом шившлэг” хэмээн хоршин хэрэглэсээр иржээ” (Цэрэнсодном 2011, 29) гэж үзжээ.

Зан үйлийн голлох илэрхийлэмж “хэл” мөн. Хэл бол зөвхөн харилцааны хэлбэр төдий зүйл бус бөгөөд зан үйл үйлдэхэд хэлж буй шившлэг үг нь зөвхөн хэллэг төдий бус өөрийн гэсэн утгат чанарыг агуулдаг. Энэ талаар Ф.де Соссюр “хэлний авиа бол дүр мөн, хэл бол тэмдэглэгдэгч, тэмдэглэгч хоёрын нэгдэл болох, утгат чанар ба утгатай болох хоёрыг ялгасан зэрэг үндэслэлийг гаргасан юм. Зан үйлээр дамжуулж ертөнц, хүн хоёрын харилцааг ойлгоход хэл чухал үүрэгтэй бөгөөд энэ утгаараа зан үйлийн хэл бол авиагаар илэрдэг дүртэй тохирох харилцаанд байдаг утгат чанараараа дамжуулж сэтгэхүйг төлөөлдөг гэсэн үг. Энэ утгаараа ойлгохуй нь интерпретацийн үүднээс утгыг ухаарахуйн үр дүн гэх герменевтик арга ухаан хөгжсөн. “Хэл бол ойлгохуйн хүрээндээ оногдохуун болж, тайлбарлахуйн хүрээндээ хэрэглүүр болж байдаг” гэж үзсэн (Гомбосүрэн 2019).

Ширгийн зан үйл дэх шившлэг үгүүдэд гарч буй хар нохой, шар нохой, хөөтэй тогоо, хөлстэй тохом, нагац зэрэг үгийн давтамж нь хүүхдийн дасал болоогүй мэдрэхүйн шинжид буюу харах, үнэрлэх, хүртэх, сонсох, хүртэхүйд мэдрэгдээгүй эрчмийг төлөөлсөн хүчин зүйлийг ерөнхий агуулгаар нь хэлж байгаагаар илэрхийлэгдэж, үгийн хүчээр засах гэсэн оролдлого гэж үзэж болмоор байна. Тиймээс дээрх эрдэмтдийн дэвшүүлсэнчлэн, хэл бол дотоод хэлбэр бүхий утгын мөн чанартай хүнийг бүтээгч соёлын хүчин зүйл бөгөөд зан үйл нь олон талт илэрхийллээрээ бүхэлдээ нийгмийн доторх үйл ажиллагаа гэж үзэх үндэстэй юм. Иймд ширгэ ширгэ шившлэг нь хүн, ертөнцийн харилцааг зан үйлээр дамжуулан ойлгох хэрэглүүр болдог. Өөрөөр хэлбэл, ширгэлэх зан үйл нь гал усыг харшуулан ширгээхдээ муу муухай бүхэн мөн адил ширгэж алга болох санаанд тулгуурлан, түүний үйлдлийг хэлээр илэрхийлэхдээ ширгэ ширгэ хэмээх хэллэгээр дамжуулж, илүү хүчжүүлэх гэсэн санаа гэж үзэх болмоор байна.

### Хэлэлцүүлэг

Зан үйл бол уламжлагдаж, хувьсаж байдаг динамик шинжтэй. Зан үйлийн уламжлал, хувьсал өөрчлөлтийн судалгаа нь зан үйлийн тогтолцоог бүрдүүлэх үндсэн хүчин зүйлүүдийг тодорхойлох боломжийг олгодог. Иймд бид хүүхэд ширгэлэх зан үйлийн орчин цагийн хэрэглээ, уламжлалын тоймыг тодруулахдаа, 2020-2024 оны хооронд 16 аймаг 123 суманд явуулсан соёлын биет бус өвийн үзлэг судалгаа, угсаатны зүйн хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүнд тулгуурласан. Тус судалгаа ажиглалт, ярилцлагын болон дүрст баримтжуулалтын аргаар явуулсан бөгөөд нийтдээ 360 гаруй өрхийг хамруулсан байна. Судалгаанаас товчлон дүгнэхэд:

1. Монголчуудын дунд хүүхдийн ширгийн төрөл төдийлөн ялгаатай бус харин ширгийн хэлбэрийн хувьд бүс нутгийн онцлогтой уялдуулан дараах онцлог харагдаж байна.
  - Баруун бүсийн угсаатны (Тува, Урианхай, Баяд) дунд чулуун дээр цог тавьж, давс, арц зэрэг ариун ургамлын зүйлсээр хүүхдийг тойруулах хөдөлгөөнөөр, хүүхдийн нүүр толгой биеийг бүхэлд нь болон толгой хэсгийг хар өнгийн дээл хувцас, даавуу зэргээр бүтээж ширгэлэх
  - Хөвсгөл, Булган зэрэг хангайн бүсийн аймгуудын дунд ус урсган ширгэлэх
  - Говь-Алтай, Ховд аймагт төмөр улайсган цоргих, ус сүрчих ширгэ
  - Хэнтий, Дорнод сүүн ширгэ хийж байгаагаараа бусад бүс нутгийнхнаас онцлог байна (Элбэс ширэг 2022).
2. Хийдэг ширгийн төрлөөр нь ангилж үзэхэд, нийт 360 өрхөөс: баруун бүс 108, зүүн бүс 96, төв бүс 89, хангайн бүс 67 өрх хамрагдсан.
  - Тугалга цутгах, лаа хайлуулах ширгэ: 166 өрх (47%)
  - Давс үсчүүлэх ширгэ: 120 өрх (33%)
  - Ус эргүүлэх ширгэ: 60 өрх (16%)
  - Бусад: 14 өрх (4%)
3. Хүүхэд ширгэлэх зан үйлийг үйлдэх шалтгаан, түүнд итгэн үнэмшиж буй байдал:
  - Хөдөө орон нутгийн 247 өрх

- Төв суурин газрын 113 өрх хамрагдсанаас 98% нь ямар нэг байдлаар хүүхэд ширгэлэх зан үйлийг гүйцэтгэдэг, хүүхдэд нөлөө үзүүлдэгт итгэн үнэмшдэг гэсэн байна.

Дээрх тойм судалгаанаас харахад, ширгийн зан үйл суурин ахуйд шилжсэнтэй холбогдуулан орчин цагийн хэрэглээнд лаа, тугалга хайлуулах, давс үсчүүлэх ширгэ түлхүү хэрэглэгдэж, үйлдэх хэрэглэгдэхүүн, арга хэлбэр нь өөрчлөгдсөн боловч зан үйлийн утга агуулга, уламжлал орчин цагтай нийцэн өвлөгдөн уламжлагдсан хэвээр байна. Хээрийн судалгааны явцад баруун бүсийн аймгуудад чулуун дээр, задгай галд, хар даавуугаар хучих, гэр тойруулах зэрэг эртний хэв шинжээ түлхүү агуулсан ширгэ үйлдэж байгаа нь ажиглагдсан. Ширгийн хэрэглэгдэхүүн, зориулалт, зан үйлийг үйлдэж буй хүнээс хамааран ширгийн итгэл үнэмшил урган гарч байна. Үүнээс гадна хүүхэд ширгэлэх зан үйлийн бэлгэдэл, мөн чанарыг ойлгон, эл зан үйлд итгэн үнэмших байдал бүс нутаг, хот хөдөөнөөс үл хамааран уламжлагдан хадгалагдсаар байгааг онцлон дурдах нь зүйтэй.

Хүүхэд ширгэлэх уламжлал хийгээд хувьсал өөрчлөлтийн судалгаанаас харахад, хүүхэд ширгэлэх зан үйл бол хүүхдийг амьдралд (хүмүүний ертөнцөд) бэхлэх үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд хүүхдэд холбогдох олон зан үйл, эдлэл хэрэглэгдэхүүнтэй утга сэжмээр холбогдсон байдаг. Энэ утгаараа амьдрал-үхлийн зөрчлийн илэрхийлэл нь хүүхдэд, түүнд хийж буй зан үйлээр илэрч байна. Энэ талаар философич С.Соёлмаа "...зөрчлүүд ихэвчлэн бие биенийхээ гүйцээлт болдог учир түүнийг зөвхөн зуучлагчийн тусламжтайгаар шийдвэрлэх албагүй, өөрөө аяндаа цэгцрэн шийдвэрлэгдэж байгаа юм. Тухайлбал, "Гэсэр" туульд амьдрал үхэл хэмээх зөрчил нь амьдрал бол үхлийн гүйцээлт, үхэл бол амьдралын үргэлжлэл болж байгаагаар шийдвэрлэгдэж байна. Энэ бол монголчуудын домгийн сэтгэлгээний аливаа зөрчлийг шийдвэрлэх гэсэн утгаараа танин мэдэхүйн арга" (Соёлмаа 2019) гэж үзсэн юм. Өөрөөр хэлбэл, монголчууд хүмүүний амьдралыг давтамжит шинжтэй гэж үздэг тул хүүхдийг тогтооход чиглэсэн аливаа зан үйл нь амьдрал-үхлийн зөрчлийг шийдвэрлэх эрмэлзлэл дээр тогтдог гэж үзэх үндэстэй. Иймд хүүхэд ширгэлэх монгол зан үйл бол зөрчлийг даван туулах арга хэрэгсэл болон амьдралын мөчлөг шилжилт дээр илэрдэг. Энэ тухай антропологич А.Женнеп зан үйл бол хүний амьдралын мөчлөг дэх шилжилт дээр илрэн гарч үйлдэгддэг талаар "Rite of passage" буюу "Давал давах ёс" бүтээлдээ тодорхой дэвшүүлсэн байдаг. Женнепийн эл онол дахь лиминал санаанаас В.Түрнер /Victor Turner/ хүний оршихуйн шинжинд үндэслэн өөрийн онолоо боловсруулсан бөгөөд тэрээр тус онолд *лиминалыг* нийгмийн амьдралын янз бүрийн үе, түвшингээс нөгөөд шилжих шилжилтийг судлах түлхүүр хэрэгсэл болгон авч үзсэн (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2012).

В.Түрнерийн тодорхойлсноор хүний зовлон бэрхшээлийг даван туулахад хийж ирсэн зан үйл (rite of affliction) нь хүмүүсийн зовлон зүдгүүрийг нимгэлэх, сайн сайхан байдлыг хангах гэсэн "туйлын хүнлэг" хэмээн нэрлэгдэх тууштай хүчин чармайлтыг харуулдаг. Мөн эдгээр зан үйл нь эерэг, сөрөг космостой холбогдох хүний төлөв байдалд тохирсон соёлын цогц илэрхийлэл болдог. Аффликяци зан үйл нь тухайн хүнийг эдгээж, хамгаалж, аливаа муу муухайг хөөж ариусган, эмх замбараагүй байдлыг залруулахыг оролддог. Хийж буй зан үйл, зан үйлийн

үйлдэгч (performer) нь тухайн соёлд үүсч буй аливаа асуудлыг тайлбарлах арга барилаас бүрэн хамаарна (Bell 1997, 119) гэжээ. Өөрөөр хэлбэл, хүний амьдралын мөчлөгт хүний хүрээлэн буй орчлон ертөнцөөс буюу ил харагдах аливаа хүчин зүйлээс гадна далдын ямар нэгэн сөрөг хүчин зүйл хүний амьдралд нөлөөлж, зовлон бэрхшээл учруулж байдаг тул түүнийг даван туулах, засах, ариусгах замаар үйлдэж ирсэн зан үйлийг rite of affliction гэж тодорхойлсон байдаг. Үүнийг хэн хэрхэн хүлээн авч, хэрхэн илэрхийлж, хэрхэн ойлгож байгаагаас хамааран зан үйл болон зан үйлийг үйлдэгчийн илэрхийлэл тодорхой ойлгогдоно гэж үзжээ. Мөн шилжилтийн лиминал үе бол аль нэг бүтэц, тогтолцоо, дүрэм журамд хамаарахгүй, ангилал тодорхойлолтод багтдаггүй завсрын нөхцөл бөгөөд тухайн нийгмээс гадна байдаг гэж үзэн энэ үеийг “коммунитас” гэж тодорхойлсон (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2012). В.Женнепийн онолын судалгаа нь зан үйл бол бие даасан судлагдахуун болох үүднээс нь ерөнхийд нь томьёолж, ангилал болгон гаргасан судалгаа бөгөөд нэг байдлаас нөгөөд шилжихэд үйлддэг зан үйл буюу зан үйл юунд яаж хэрэглэгддэг, ямар зориулалттай байдаг, юунд хөшүүрэг болж зан үйл буй болдог талаар баримталж гаргасан онол бол, В.Түрнерийн онол тухайн зан үйлийн мөн чанар хүний оршихуйн шинжинд үндэслэсэнээрээ ялгаатай.

Зовлон бэрхшээлийг даван туулахын төлөөх зан үйлийн талаар лиминал онолд авч үзэхдээ лиминал үед хүмүүс нийгмийн статусаас түр холдож, өөрсдийгөө шинэ утга учиртай болгож өөрчилдөг (Turner 1991) гэж үзсэн юм. Харин лиминал дахь аффликяц нь энэхүү шилжилтийн гол элемент болж, хүмүүс зовлон, хямралынхаа үед нийгмийн тогтсон хэм хэмжээнээс түр чөлөөлөгдөж байгаагаар илэрхийлэгддэг. Лиминал байдалд байгаа үед хүмүүс хямрал, зовлонгоо даван туулж, дараа нь нийгэмдээ шинэ статустайгаар эргэн нэгддэг тул аффликяци нь лиминал байдлын дотоод утгыг илүү нарийн ойлгоход чухал үүрэгтэй. Хүүхэд ширгэлэх зан үйл, түүний бэлгэдэл нь лиминал байдлын тод жишээ мөн бөгөөд тухайн хүүхдийг ширгэлж буй мөчлөг бол зөрчлийн үед нийгмээс өөрийгөө түр хугацаанд тусгаарлаж буй хэрэг мөн бөгөөд энэ нь эргээд гэр бүл цаашлаад нийгэм дэх харилцааг засахад чиглэдэг. Өөрөөр хэлбэл, аливаа айдас, зовлон, бэрхшээлээс үүдэлтэй буй болсон нөхцөл байдлыг зан үйлээр дамжуулан засаж залруулах гэсэн санаа бөгөөд түүний бэлгэдэл дэх аффликяци утга нь нийгмийн эв нэгдлийг бий болгодог гэж үзэж болох юм.

### Дүгнэлт

Монголчууд хүүхдийг төрсөн цагаас эхлэн хүүхдийн амь нас, эрүүл мэндийг элдэв аюул, заналхийллээс аварч хамгаалах хуурч, аргалах гэх мэтийн дом, бэлгэдэлт зан үйлийн нэг болох “ширгэ”-ийг ахуй амьдралдаа уламжилсаар өнөөг хүрчээ. Усанд цог, халуун төмөр, тугалга, лаа зэргийг хийж дуу гарган, усыг шогшоолгон ширгээдгээс үүдэн “ширгэ” хэмээн нэрлэж хэвшсэн бололтой. Дэлхий олон угсаатан, ард түмний дунд rite of magic protection/apotropaic magic буюу утгачилбал, хүүхдийг хорон муу зүйлээс хамгаалах шидийн зан үйл хэмээх утгаар ойлгож үйлддэг байсан нь монголчуудын хүүхэд ширгэлэх зан үйлтэй олон талаар төсөөтэй байна.

Хүүхэд ширгэлэхдээ гал, ус, давс, төмөр, чулуу зэрэг өөрсдийн амьдрал ахуйд мөн чанарыг танин мэдсэн хэрэглэгдэхүүнийг ашиглан үйлддэг онцлогтой. Монголчууд галыг эх үүтгэлт, хүүхдийн бурхан, үр хүүхдийг ивээгч, хамгаалагч хэмээн шүтэж ирснийг хүүхдийн онго, зүүсгэл тэргүүтнээс эхлээд ахуй амьдралын арвин баялаг зан үйлээс харж болохоор байна. Галыг ариулах шидтэй, хүүхдийн бат даатгал, өөдөө эрчимтэй гэж үзвэл ус нь үүний эсрэг утга бүхий уруу урсгалтай, шингээгч эрчимтэй. Хүйтэн чанартай усанд халуун чанартай, галыг төлөөлөгч бэлгэдэл бүхий зүйлсийг хийн шогшоолгон ширгээж буй тус зан үйл нь сайн ба муу, хоргоогч ба хамгаалагч, эсрэг тэсрэгийн нийлэмж болохын хувьд аливаа мууг эвцэлдэн дарж, амийг хамгаалж буйгаараа афликяцийн зан үйл хэмээн үзэх үндэстэй.

Мөн 2020-2024 оны хооронд явуулсан хээрийн судалгаа, баримтжуулалтаас үзэхэд, ширгэлэх зан үйл суурин ахуйд шилжсэнээс үүдэн үйлдэх арга барил нь өөрчлөгдсөн боловч тус зан үйлийг үйлдэх шалтгаан, итгэн үнэмшиж уламжлуулах байдал амьдралын орчин, бүс нутгийн ялгаанаас үл хамааран мөн чанараараа уламжлагдан хадгалагдсаар байна.

Зан үйл нь хүмүүсийн танин мэдэхүйн явц бөгөөд хүн, ертөнцийг танин мэдэх, ойлгох түүнтэй харилцах харилцааг аливаа үйл хөдлөлөөр илэрхийлэх тул зан үйлийг хүн ертөнцийн харилцааг зохицуулдаг гэж үзэх үндэстэй юм. Монгол зан үйл, тэр дундаа хүүхэд ширгэлэх зан үйл нь хүн ба орчлон ертөнцийн хоорондох эвцэл, зөрчлийн үр дүн болж илрэх бөгөөд энэ утгаараа зан үйл дэх утга, бэлгэдэл дэх афликяци нь нийгмийн эв нэгдлийг бий болгодог хүчин зүйл гэж үзүүштэй.

Хүүхэд ширгэлэх зан үйлийн үйлдэгч хийгээд үйлдүүлэгчийн хоорондох харилцаа, түүний бодомжид аливаа гай түйтгэр ирэх, түүнийг хөөн зайлуулах үйл явц нь сав, шим ертөнцийн /ил, далд/ уулзвар дээр давхцан илэрч байна. Өөрөөр хэлбэл, зан үйл судлалын лиминал ойлголт дахь афликяци утга нь ганц хүмүүний гүйцэтгэл байхад монгол зан үйлд эл ойлголт нь зориулалт, хэрэглэгдэхүүн, гүйцэтгэгч, тусагдахуун зэргээр хүмүүний оршихуйн үзэл төсөөллөөр баяжигдан сав, шим ертөнцийн уулзварт оршдог хэмээн тодорхойлж болмоор байна.

### Ашигласан материалын жагсаалт

#### Монгол хэлээр:

Баатархүү, Бат-Өлзий. 2017. *Монгол улсын тувачууд*. Улаанбаатар.

Бум-Очир Д., Мөнх-Эрдэнэ Г. 2012. *Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд*. Улаанбаатар: МУИС пресс.

Гомбосүрэн, Цэдэндагва. 2019. *1990-ээд оноос хойшхи монголын философийн амьдрал: Сэдэвчилсэн тоочилт, зэрэгцүүлэл ба харьцуулал*. Улаанбаатар: Артсофт.

Дулам, Сэндэнжав. 2011. *Монгол бэлгэдэл зүй III боть: Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй*. Улаанбаатар: Адмон.

Дулам, Сэндэнжав. 2013. *Монгол соёл иргэншлийн утга тайлал*. Улаанбаатар: Бит пресс.

Золбаяр Г., Ганболд М., ба бус. 2014. “Алтайн Урианхайн угсаатны зүй.” Ред. Золбаяр Г. Баян-Өлгий дахь нийгэм эдийн засгийн судалгааны төв. Китаб.

Пүрэв, Отгон. 2014. *Монгол бөөгийн шашин*. Улаанбаатар: Адмон принт.

Соёлмаа, С. 2019. *Домгийг бүтэц тэмдэг зүйн үүднээс шинжлэхүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Тангад, Данаажав. 2020. *Монгол домын тайлбар толь*. Улаанбаатар: Сэлэнгэпресс.

Цэрэнсодном, Далантай. 2012. *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Улаанбаатар: Тод бичиг.

### **Хээрийн судалгааны тайлан:**

2020. *Миний монгол төсөл*. Metadata тайлан.

2021. *Миний монгол төсөл*. Metadata тайлан.

Баядын өв соёл ТББ. 2024. *Баядын өв соёл хээрийн судалгаа*. Баядын өв соёл ТББ-ын архив.

Соёлын яам. 2022. *Элбэс ширэг: Эх амаржих, хүүхэд өсгөхтэй холбогдох монгол домын соёл төсөл*. Соёлын яаманд.

Соёл урлагийн газар. 2022. *Зүүн бүсийн Соёлын биет бус өвийн улсын үзлэг, судалгаа*. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг.

Соёл урлагийн газар. 2023. *Хангайн бүсийн Соёлын биет бус өвийн улсын үзлэг, судалгаа*. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг.

Цахим Суварга ТББ. 2022-2023. *Хээрийн судалгаа, зураг авалт*. Metadata тайлан.

### **Гадаад хэлээр:**

Bell, Chaterine. 1997. *Ritual: Prespectives and dimensions*. New York: Oxford University press.

Cossu, Andrea. 2010. “Durkheim’s argument on ritual, commemoration and aesthetic life: A classical legacy for contemporary performance theory?” *Journal of Classical Sociology* (Sage) 10: 33-49. doi:: <http://www.sagepub.co.uk/journalsPermissions.nav> .

Genep, Arnold van. 1961. *The rites of Passage*. Chicago: University of Chicago Press.

Hutton, Ronald. 1996. *History of the ritual year in Britian* . New York: Oxford Unversity Press. [https://books.google.mn/books?id=t-P24jQyfP0C&printsec=frontcover&source=gbg\\_summary\\_r&cad=0#v=onepage&q&f=false](https://books.google.mn/books?id=t-P24jQyfP0C&printsec=frontcover&source=gbg_summary_r&cad=0#v=onepage&q&f=false).

Lesley, Beaumont. 2015. *Childhood in Ancient Athens: Iconography and Social History*. New York, Routledge



Robert, Kriech Ritner. 2008. *Mechanics of Ancient Egyptian magical practice*. 4. Vol. 59. Chicago, Illinois: Oriental Institute.

Turner, Victor. 1967. *The forest of Symbols. Aspects of Ndembu ritual*. New York: Cornell University Press.

Turner, Victor. 1991. *The Ritual Process: Structure and anti-structure*. New York: Cornell Paperbacks.